



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/863

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн алдарт малчин, аварга малчин тэмдэг захиалан хийлгэх зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 18 336 300 төгрөг /Арван найман сая гурван зуун гучин зургаан мянга гурван зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас хамгаалах зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 24-ний өдрийн  
А/863 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН АЛДАРТ МАЛЧИН, АВАРГА МАЛЧИН ТЭМДЭГ  
ЗАХИАЛАН ХИЙЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| Д.д | Тоног төхөөрөмжийн нэр төрөл              | ХНэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Дүн /мян.төг/ |
|-----|---|-------|------------|-------------------------|---------------|
| 1.  | Аймгийн алдарт малчин тэмдэг /хайрцагтай/ | ш     | 150        | 37 125                  | 5 568.8       |
| 2.  | Аймгийн аварга малчин тэмдэг /хайрцагтай/ | ш     | 300        | 37 125                  | 11 137.5      |
| 3.  | Үнэмлэх                                   | ш     | 420        | 1 500                   | 630.0         |
| 4.  | Эх бэлтгэл хийлгэх зардал                 | ш     | 1          | 1 000 000               | 1 000.0       |
| ДҮН |   |       | 420        |                         | 18 336.3      |

-оОо-